



**БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС ДАХЬ
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТӨВ**

Сөүл хот, Жүнгү дүүрэг, Тэгерү 324,
Сон-ву барилга 4 давхар, утас: 02 2278 8030, 02 2266 9229
E-mail: info@seoulcenter.mlsp.gov.mn

2026.06.29 № 1/108
танай _____-ны № _____-т

Биелэлт хүргүүлэх тухай

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт ..6.... хуудастай.

Хүндэтгэсэн,

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ЖАРГАЛМАА

000153

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2026 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 1/108 тоот албан бичгийн хавсралт

**БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**
(2026 оны эхний хагас жил)

д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Шийдвэрийн дэс дугаар	Зүйл заалтын дэс дугаар	Биелэлт	Үнэлгээний /Шалтгаан/					Хэрэгжих боломжгүй	Хяналтаас хасуулах тухай санал /хүчингүй болгох эсэх/	
					Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд		Хэрэгжэ эгүй				Хугацаа болоогүй
						Тодорхой үр дүнд хүрсэн	Удаашралтай /эрчимжүүлэх шаардлагатай	Зохион байгууллалтаас	Хөрөнгө дутсанаас			
1.е. Засгийн газрын тогтоол												
1	БНСУ-д Нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах тухай, 2011.10.26 1."БНСУ-д ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдэд хөдөлмөр, нийгмийн даатгал болон халамж, хүн ам, гэр бүлийн асуудлаар зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, тэтгэврийн даатгалд хамруулах, монгол иргэдийн БНСУ-д төлсөн шимтгэлийг буцаан олгуулах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий "Нэг цэгийн	306	1	БНСУ-д ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдэд хөдөлмөр, нийгмийн даатгал, нийгмийн халамж, гэр бүлийн асуудлаар зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх, тэтгэврийн даатгалд хамруулах асуудлыг тухай бүр хариуцан ажиллаж байна. Тухайлбал, Хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгааллын чиглэлээр утсаар 971, цахимаар 372, танхимаар 279, явуулын үйлчилгээгээр 318, нийт 1940 иргэнд хууль эрх зүйн зөвлөгөө мэдээлэл хүргэн, орчуулгын тусламж үйлчилгээ үзүүлсэн. Хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлаа шийдвэрлүүлэхээр хандсан 214 иргэний өргөдөл, гомдлыг хүлээн авч, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, ажил олгогч эзэд болон	100							

				Төрийн албан хаагчийг томилох, чөлөөлөхтэй холбоотой өргөдөл, гомдол бүртгэгдээгүй байгаа болно.									
6	“Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2025.07.25 1.2. Төрийн албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авч, байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргахгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоо болон сул орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүй байх	04	1.2	Албан даалгаврын хэрэгжилтийг ханган, орон тоо нэмэгдүүлэх ямар нэг санал хүргүүлээгүй.	100								
7	“Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2025.07.25 1.3.иргэддээ чин шудрагаар үйлчилдэг, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх зорилгод нийцүүлэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдүүлэх, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах	04	1.3	Төрийн албаны зөвлөлийн “7:4:10” цахим-Вебинар мэдээллийн цагт 2026 оны 05 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулагдсан “Байгууллагын ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээ ба арга зүй” сэдэвт сургалтад нийт албан хаагчид хамрагдав. Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ”-г албан хаагчдад түгээн, байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан.	90								
8	“Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2025.07.25 1.7.Төрийн албаны тухай хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албан хаагчдыг төрийн албанаас чөлөөлөхгүй, халахгүй, хуулиар чиг үүрэгт нь өөрчлөлт ороогүй тохиолдолд	04	1.7	Албан хаагчдыг чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах, шилжүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргахдаа Төрийн албаны тухай хуулийг мөрдлөг болгон ажиллаж байна.	100								

	төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахгүй байх, төрийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөн боловч албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг нь хэвээр хадгалагдан үлдсэн төрийн жинхэнэ албан хаагчдыг чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах, шилжүүлэх шийдвэр гаргахгүй байх														
Хэсгийн дундаж: 98.75 хувь															
2.а.Монгол Улсын хууль															
9	Нийгмийн даатгалын ерөнхий хууль, 2023.07.07 37.10.Гадаад улсад түр болон байнга оршин сууж хөдөлмөр эрхэлж байгаа Монгол Улсын иргэнийг нийгмийн даатгалд хамруулж, нийгмийн баталгааг хангах, шимтгэлийн орлого бүрдүүлэх, гадаад улстай байгуулсан Монгол Улсын нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий нийгмийн даатгалын байгууллагын салбар нэгжийг тухайн улсад ажиллуулж болно.		37.10	БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар шинээр ирсэн болон ажиллаж байсан нийт 190 гэрээт ажилтныг тэтгэврийн даатгалд албан журмаар шинээр хамруулсан бол бусад төрлийн визээр оршин суугаа 224 иргэнийг сайн дурын даатгалд шинээр хамруулсан. 2026 оны албан журмын даатгуулагчийн суурь түвшин 1541-т, сайн дурын даатгуулагчийн суурь түвшин 1352-т хүрсэн. Монгол Улсын Нийгмийн даатгалд хамрагдсан 270 иргэнд БНСУ-ын тэтгэврийн даатгалаас чөлөөлөх гэрчилгээ олгосон. Монгол Улсын Нийгмийн даатгалд албан журмаар даатгуулсан 329 иргэнд, сайн дураар даатгуулсан 270 иргэнд БНСУ-ын нийгмийн даатгалаас чөлөөлөх гэрчилгээг олгосон. Тайлант хугацаанд тэтгэвэрийн албан журмын даатгалд 540,879,400.00 төгрөг, сайн дурын даатгалд 862,444,601.61 төгрөг, Нийгмийн даатгалын санд 1,403,324,001,61 төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлсэн. Тайлант хугацаанд шимтгэл төлөлтөд сар бүр хяналт хийж, шимтгэлийн авлага барагдуулах арга хэмжээ авч шимтгэл төлөөгүй ажил олгогч,	100										

				байгууллагад нэхэмжлэл илгээн, сайн дураар даатгуулах гэрээгээр тохирсон хугацаанд шимтгэл төлөөгүй даатгуулагчидтай утсаар холбогдож шимтгэлийг төлүүлснээр нийт 319 даатгуулагчийн 282,918,441.00 төгрөгийн шимтгэлийн авлагыг барагдуулсан.									
Хэсгийн дундаж: 100 .хувь													
Нийт дундаж: 99.37 хувь													

--- оОо ---